

Ээлжит хичээлийн төлөвлөлт 2

Сар өдөр: 11 сарын 16

Сургууль: 5-р сургууль


Анги: 8


Сурагчдын тоо:

Сэдэв: Шугаман тэгшитгэл зохиох

Зорилго: Асуудлын утга санааг шугаман тэгшитгэлээр илэрхийлэх, шугаман тэгшитгэл ашиглан тодорхой асуудал шийдэх чадвар төлөвшүүлэх

Үе шат, хугацаа	Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа	Тайлбар ❖ Анхааруул га
Сэдэлжүүлэх 6 минут		Мэндлэх	
	<i>-Тэгш өнцөгт</i> - 4 $-4 \times 1 = 4$ $-4 \times 2 = 8$ $-4 \times 3 = 12$ гэх мэт Бодоод: 16, 20, 40, 100 Хариулт: - 4x Нэг цаасан дахь соронзны тоог цаасны тоогоор үржихэд нийт соронзны тоо гарна гэдгийг үгээр хэлж, 4x илэрхийлэл зохионо. Хариулт: Тэгшитгэл	Анги зохион байгуулалт хийх. Нүүр хагарах, мөс хагалах, тархины шуурга гэх мэт Тэгш өнцөгт хэлбэртэй цаас үзүүлэн энэ ямар дүрс вэ? Тэгш өнцөгтийн булан бүрт нэг нэг соронз байхаар тогтооё. - Нэг тэгш өнцөгтийг тогтооход хэдэн соронз хэрэглэсэн бэ? Тэгш өнцөгтийн тоог нэмэгдүүлэн хэдэн соронз хэрэгтэйг асууна. Тухайлбал: 4, 5, 10, 25 үед - Яг ийм байдлаар x ширхэг тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг тогтооход хэдэн соронз хэрэгтэй вэ? 4x нь илэрхийлэл үү, тэгшитгэл үү? -Багш x ширхэг цаас тогтооход 560 ширхэг соронз хэрэглэсэн. Тэгвэл би хичнээн тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг самбарт тогтоосон бэ? \ <u>Үзүүлэн №2\</u> - 4x=560 бид нар ямар бодлого бодсон бэ? Хариултаас – Багш Хичээлийн сэдвийг	Цаг хэмнэхийн тулд цаасаа тогтоож байх явцдаа асуух Соронзны тоо x Цаасны тоо = Нийт Соронзны тоо үзүүлэн №1 бэлдсэн байх Сорилгын бодлого 2 оос харахад: тэгшитгэл илэрхийллийн ялгааг хэлж өгөх Үзүүлэн 11 ийг ашиглахыг анхааруулах Бодлогын өгүүлбэр бичсэн – үзүүлэн №2 бэлдэх

Мэдлэг бүтээх 20 минут	Нэг сурагч самбарт гарч цаасны булан бүр дээр 1, 1 соронз байхаар аль болох олон цаас тогтооно   гэх мэт багш чиглүүлж харилцан ярилцах  X Сурагчид дэвтэр дээрээ тоцоолон бодох - 4,6, 8 ... - $2x+2$ - $4+2(x-1)$ - $4x-2(x-1)$ - $2(x+1)$ гэх мэтээр илэрхийлэл зохионо. /Зохиосон илэрхийлэлээ бусдад тайлбарлана / Хувилбар бүр дээр тэгшитгэлийг бодох Багууд багшийн тарааж өгсөн цаасан дээр бодолтоо бичиж самбарт гаргана.	самбарт бичнэ. 8-н соронз ашиглаад булан бүрт нэг соронз байхаар 2-оос илүү цаас тогтоож болох уу? Асуулт: - x ширхэг цаасыг тогтооход хэдэн соронз орохыг олоорой. Илэрхийлэл зохиолгоно. Сурагчдын бодолтыг тайлбарлуулах Хувилбаруудаас сонгож самбарт бичнэ. Олон хувилбар гарч ирээгүй тохиолдолд багш хамтран илэрхийлэл зохионо. /Сурагчдаар тайлбарлуулна. / Сурагчдаар ийм байдалтай тэгшитгэл зохиолгоно. Бодлого: 30 ширхэг соронзоор хэдэн ширхэг цаасыг тогтоох вэ? Баг бүрт илэрхийллийн хэлбэрүүдийг өгөөд түүнийг тэгшитгэл болгож бодох даалгавар өгнө. Сурагчдын дэвтэр дээрхийг хянах Самбарт алдааны судалгаан дээр үндэслэн бодлогыг тайлбарлах, тайлбарлах явцдаа илэрхийллийн хэлбэрүүд адилтгал тэнцүү илэрхийлэл байсан гэдгийг анхааруулах -Үржвэрийг үржигдэхүүнд хуваах -Гишүүнчлэн үржүүлэх үйлдэл Шугаман тэгшитгэлийн тайлбар болон тодорхойлолтыг гаргаж өгөх $ax=b$ $ax+c=b$ $a+k(x-c)=b$ $ax-k(x-c)=b$ $a(x+c)=b$ гэх мэтээр	Цаас, соронз бэлдэх Цаасыг салгаж хувилбар гаргах $2x+2$ нь цаасны тоо юу? соронзны тоо юу? Тэгшитгэл зохиолгохыг зорих \ тодорхойлолт бичсэн үзүүлэн №3 \
--------------------------------------	---	--	---

Мэдлэгээ бататгах 12 минут	Багшийн асуултанд хариулах - Соронзны тоог тооцож гаргах - $3x$ - $1+2x$ - $3+2(x-1)$ - $x+x+1$	Гурвалжин дүрс харуулах -Мөн гурвалжны орой бүр дээр соронз байхаар тогтооё 4-н гурвалжинд хичнээн соронз орох вэ?  Бодлого: Гурвалжны орой бүр дээр соронз байхаар аль болох цөөн соронз ашиглаад хэрхэн тогтоож болох вэ? Бодлого: Тэгвэл x ширхэг гурвалжинд хэдэн соронз ашиглагдах вэ? Багш нэг хэлбэрийг сонгоод тэгшитгэлийг бодож харуулна. Гэрийн даалгавар: Тэгш өнцөгт болон гурвалжин дүрсээ ашиглаад өөр ямар боломжоор илэрхийлэл зохиож болох вэ? Хувилбаруудыг олж ирэх \ Мөн гэрийн даалгаварт шүдэнз ашиглан бодох сорилгын бодлогыг өгч болно.\	Багаар ажиллуулах: (баг бүрт нэг самбар 4ш гурвалжин дүрс, соронз) Сайн байна, Болж байна, гэх мэтийн урамшууллын үгийг хэлнэ. Хэрэв энэ байрлалаар гаргаж ирэхгүй байвал дахин өөр ямар боломж байж болох гэж байгад гаргаж ирүүлэх
Дүгнэх-2 мин	Хичээлийг дүгнэн ярилцах	-Өнөөдрийн хичээлээр юу ойлгосон бэ? -аль хэсэг нь сонирхолтой байсан бэ? • Асуудлын утга санааг шугаман тэгшитгэлээр илэрхийлэх • Шугаман тэгшитгэлээр асуудлыг шийдвэрлэх	

Ашиглах бэлэн хэрэглэгдэхүүн:

1. Багшид: Тэгш өнцөгт хэлбэртэй өнгийн цаас А5- 14ш , соронз 54 ш, үзүүлэн 1, үзүүлэн “2
2. Сурагчид: 16ш гурвалжин, соронз 48ш, гар самбар 4ш
3. А3 цаас 4ш,өнгийн харандаа

Бэлтгэх хэрэглэгдэхүүн:

Үзүүлэн¹ Соронзны тоо x Цаасны тоо =Нийт Соронзны тоо

Үзүүлэн² Бодлогын өгүүлбэр

Багш x ширхэг цаас тогтооход 560 ширхэг соронз хэрэглэсэн. Тэгвэл би хичнээн тэгш өнцөгт хэлбэртэй цаасыг самбарт тогтоосон бэ?

Үзүүлэн'3 Шугаман тэгшитгэлийн тодорхойлолт



